



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/248

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.12, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "Аймгийн 2019 оны төсөв батлах тухай" 8/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Чандмань суманд үндэсний соёлын уламжлалт өв болсон хөөмий, бий биелгээг хүүхэд залуучуудад өвлүүлэн хөгжүүлэхэд шаардлагатай байгаа хөгжмийн зэмсэг худалдан авах зардалд зарцуулах 2250.0 мянган төгрөгийн төсвийг хавсралтаар баталсугай.

2.Тус арга хэмжээнд зарцуулах 2250.0 мянган төгрөг /хоёр сая хоёр зуун тавин мянган/- ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 5.25 дахь заалтын "Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр"-өөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны  
4 дүгээр сарын 19-ний  
өдрийн А/248 дугаар захирамжийн хавсралт

ЧАНДМАНЬ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД  
ОЛГОХ ХӨГЖМИЙН ЗЭМСЭГ ХУДАЛДАН АВАХ ЖАГСААЛТ

ДД	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Морин хуур	ш	3	550000	1650000
2	Аман хуур	ш	10	30000	300000
3	Нуман хуур	ш	10	30000	300000
	Дүн				2250000

-oOo-